



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

┌ Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх ┐  
тусгай зөвшөөрөл олгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн арван наймдугаар хавсралт “Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 2.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хавсралтад дурдсан нэр бүхий 2 иргэнд “Агула даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгогдсон иргэдэд “Агула даатгал” ХХК-аас бусад даатгалын компанид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхгүй болохыг анхааруулсугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн  
358 дугаар тогтоолын хавсралт



“Агула даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгох иргэдийн товч мэдээлэл

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр	Хаяг, утасны дугаар	Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх даатгалын хэлбэр
1	Энхжаргал	Уянга		Улаанбаатар		Гэнэтийн осол, эмчилгээний, Хөрөнгийн, Автотээврийн хэрэгслийн, Ачааны, Барилга угсралтын, Агаарын хөлгийн, Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын, Хариуцлагын, Санхүүгийн, Зээлийн, Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
2	Төмөрбаатар	Эрдэнэцэцэг		Улаанбаатар		Гэнэтийн осол, эмчилгээний, Хөрөнгийн, Автотээврийн хэрэгслийн, Ачааны, Барилга угсралтын, Агаарын хөлгийн, Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын, Хариуцлагын, Санхүүгийн, Зээлийн, Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал